

2003 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

Аргачлал, үнэлгээ батлах тухай

Газрын тухай хуулийн 24.3, 58.8-д болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ”-г 1 дүгээр хавсралт, “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээ”-г 2 дугаар хавсралт, “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үнэлгээ батлах тухай” Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 119 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ө.ЭНХТҮВШИН

Хянасан:
Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын дарга

Ө.ЭНХТҮВШИН